



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 30 өдөр

Дугаар А/165

Хэрлэн сум

Нөөц хөрөнгийн зардлыг
санхүүжүүлэх, тайлагнах тухай.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, 66.3 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны "Журам шинэчлэн батлах тухай" 61 дүгээр тушаалыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Засаг даргын нөөц хөрөнгийн зорлуулалт, зарцуулалтын нийтлэг журам шинэчлэгдэн батлагдсантай холбогдуулан нөөц хөрөнгийн санхүүгийн гүйлгээ хийхэд 1 дүгээр гарын үсгийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга, 2 дугаар гарын үсгийг аймгийн Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч нар зурж баталгаажуулж байхаар тогтоосугай.

2.Нөөц хөрөнгийн зарцуулалтын тайланг журамд заасны дагуу гаргаж аймгийн Засаг даргын Тамгын газарт хугацаанд нь ирүүлж ажиллахыг тухайн арга хэмжээ, төслийг хариуцан гүйцэтгэсэн байгууллага, ажилтан нарт даалгасугай.

3.Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалт, тайлагналтад хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2019 оны А/10 тоот захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

231016452